

БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ

Хөтөлбөрийн товч танилцуулга

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Боловсролын солилцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Боловсролын яам хоорондын Монгол Хятадын тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн дагуу бакалавр, магистрантур, докторантурын сургалтад суралцуулна. Нийт элсүүлэх оюутны тоо 200-300

Шалгуур үзүүлэлт

- **Ахисан төвшний хөтөлбөр (Хугацаа: 3-6 дүгээр сар)**

Тэтгэлгийн хугацаа	Магистрын зэрэг	2-5 жилийн хугацаатай сургалт
	Докторын зэрэг	2-5 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой. <ol style="list-style-type: none">1. Магистрантурт суралцах бол бакалаврын зэрэгтэй, 35 хүртэлх насны Монгол улсын иргэн байх;2. Докторантурт суралцах бол магистрын зэрэгтэй, 40 хүртэлх насны Монгол улсын иргэн байх ;3. Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх;4. Мэргэжлээрээ 2-3 жил ажилласан байх, Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (Хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлүүдийн жагсаалт, сонгосон чиглэлээр суралцах сэдвийн хүрээнд бичсэн автореферат; магистрын сургалтад өргөдөл гаргах иргэд хавсаргах шаардлагагүй ч хавсаргавал давуу талтай)	

- **Бакалаврын хөтөлбөр(Хугацаа: 3-6 дүгээр сар)**

Тэтгэлгийн хугацаа	Бакалаврын зэрэг	5 жилийн хугацаатай сургалт
Шалгуур	Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой;	

үзүүлэлт

1. Өргөдөл гаргагч нь 17-25 нас хүртлэх Монгол улсын иргэн байх.
2. Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх.
3. Бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээний голч дүн 80-аас дээш, их дээд сургуулийн 1-2-р курст суралцдаг бол голч дүн 3,0 ба түүнээс дээш байх.

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Бүртгэл тухайн жилийн 3 дугаар сард явагдана

2



Бакалавр, магистрантур, докторантурын сургалтад бүртгүүлсэн иргэдийн сонгон шалгаруулалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамнаас томилсон хамтарсан ажлын хэсэг зохион байгуулна.

3



Ярилцлагад тэнцсэн бүртгүүлэгчдийн нэрсийг БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны үүдний самбарт болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудас дахь “гадаадад суралцах” цэсэд тус тус байрлуулна.



Тухайн нэр дэвшигчийг хүлээн авч суралцуулах эцсийн шийдвэрийг БНХАУ-ын Боловсролын яам, хүлээн авах сургууль хамтран гаргана.

Дэлгэрэнгүй мэдээллийг авах бол

- www.csc.edu.cn/studyinchina
- www.campuschina.org